



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь мониторингийн тайлан, шалгалтаар тогтоогдсон, түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй “Сарны чулуу анар” ХХК-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 12900324 тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хуулийн этгээдийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3.Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасан хугацаанд шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАГҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР